



ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН
ХИЛ ХАМГААЛАХ ЕРӨНХИЙ ГАЗРЫН
ДЭРГЭДЭХ САЛБАР ЗӨВЛӨЛИЙН
ТОГТООЛ

2022 оны 07 сарын 18 өдөр

Дугаар 14

Улаанбаатар хо

「Хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөрийг
батлах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.9, 8 дугаар зүйлийн 8.3.5, 8.4, Монгол Улсын хилийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Хил хамгаалах байгууллагын “Хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөр”-ийг хавсралтаар баталсугай.

2.Тушаалыг 2022 оны 08 дугаар сарын 01-ний өдрөөс мөрдөж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргааны удирдлага эрхэлсэн дэд дарга (бригадын генерал Д.Мөнгөнжин), Хүний нөөцийн бодлого, зохицуулалтын газрын дарга (хурандаа Х.Гантулга), хилийн цэргийн анги, тусгай салбарын захирагч нарт үүрэг болгосугай.

ДАРГА,
БРИГАДЫН ГЕНЕРАЛ



Х.ЛХАГВАСҮРЭН

Хил хамгаалах ерөнхий газрын дэргэдэх
Төрийн албаны зөвлөлийн Салбарын
зөвлөлийн 2022 оны ... дугаар сарын ... -ны
өдрийн дугаар тогтоолын
хавсралт

ХИЛ ХАМГААЛАХ БАЙГУУЛЛАГЫН ХҮНИЙ НӨӨЦИЙН ХӨГЖЛИЙН ХӨТӨЛБӨР

Нэг.Нийтлэг үндэслэл.

1.1.Монгол Улсын хилийн тухай хууль, Улсын их хурлын 2002 оны 20 тогтоолоор батлагдсан “Төрөөс хилийн талаар баримтлах бодлого”, Улсын их хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор батлагдсан “Алсын хараа-2050 хөтөлбөр”, Засгийн Газрын 2012 оны мн/110 дугаар тогтоолоор батлагдсан “Бүсчилсэн хил хамгаалалт хөтөлбөр”, Байгууллагын стратеги төлөвлөгөө нь байгууллагын хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөр (цаашид “Хөгжлийн хөтөлбөр” гэх) боловсруулах эрх зүйн үндэслэл болно.

Хоёр.Хөгжлийн хөтөлбөрийн зорилго.

2.2.Улсын хил хамгаалалтын арга тактикийн өөрчлөлт, техник технологийн шинэчлэлтэй уялдуулан мэргэжлийн, мэргэшсэн хүний нөөцийг бүрдүүлэх, зөв байршуулах, хөгжүүлэх, бүтээлч, чадварлаг, тогтвор суурьшилтай хүний нөөцийг бий болгож, хилчдийн нийгмийн баталгааг хангах нэгдсэн бодлогыг тодорхойлж, Хил хамгаалах байгууллагын "Хүний нөөцийн дүрэм"-ийг хэрэгжүүлэхэд энэхүү хөгжлийн хөтөлбөрийн зорилго оршино.

Гурав.Хөгжлийн хөтөлбөрт баримтлах зарчим.

- 3.1.хууль дээдлэх;
- 3.2.ёс зүйтэй, ил тод, шударга, нээлттэй байх;
- 3.3.авлигаас ангид байх;
- 3.4.чадахуйн (мерит) зарчмыг баримтлан шатлан дэвшүүлэх;

Дөрөв.Хэрэгжүүлэх үе шат, хугацаа.

4.1.Хөгжлийн хөтөлбөрийг 2022-2030 оны хооронд 2 үе шаттайгаар хэрэгжүүлнэ.

- 4.1.1. Нэгдүгээр үе шат нь 2022-2026 он /4 жил/
- 4.1.2. Хоёрдугаар үе шат нь 2027-2030 он /4 жил/

4.2.Хөгжлийн хөтөлбөрийн үе шат бүрд хүний нөөцийн судалгаанд үндэслэн төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлнэ.

Тав.Хөгжлийн хөтөлбөрийн зорилт.

5.1.Хүний нөөцийн хэрэгцээ, өнөөгийн байдлын түвшинг харгалзан хөгжлийн хөтөлбөрийг дараах зорилтын хүрээнд хэрэгжүүлнэ.

5.1.1.байгууллагын хөгжлийн бодлоготой уялдуулсан мэргэжлийн, мэргэшсэн хүний нөөцийг бүрдүүлж, хүний хөгжлийг хангана;

5.1.2.хилчдийн нийгмийн баталгааг хангаж, алба хаагчийг идэвхжүүлэн урамшуулна;

5.1.3.хүний нөөцийн цахим удирдлага, мэдээллийн системийг хөгжүүлнэ;

Зургаа.Зорилтыг хэрэгжүүлэх бодлого.

6.1.Байгууллагын хөгжлийн бодлоготой уялдуулан мэргэжлийн, мэргэшсэн хүний нөөцийг бүрдүүлж, хүний хөгжлийг хангах зорилтын хүрээнд баримтлах бодлого.

6.1.1.цэргийн мэргэжлийн офицерын нөхөн хангалтыг нэмэгдүүлж, эзэмшсэн мэргэжилд тулгуурлан оновчтой, зөв байршуулна.

6.1.2.улсын хил хамгаалалтын арга тактикийн өөрчлөлт, шинээр нэвтрүүлэх техник технологитой уялдуулан тусгай мэргэжлийн хүний нөөцийг захиалгаар бэлтгэнэ.

6.1.3.гадаад харилцааг өргөжүүлж, өндөр хөгжилтэй улс орнуудад алба хаагчдыг сургаж, мэргэшүүлнэ.

6.1.4.алба хаагчийн эзэмшсэн боловсрол, мэргэжил, ажлын дадлага, туршлага, ёс зүйн байдал, ажлын үр дүнг харгалзан удирдах болон дэвшүүлэх албан тушаалтны нөөц бүрдүүлж, шатлан дэвшүүлнэ.

6.1.5.стратегийн болон оперативийн түвшний боловсролтой алба хаагчийг нэмэгдүүлж, удирдах албан тушаалтныг бэлтгэнэ.

6.1.6.албан тушаалд бэлтгэх болон ажлын байран дээрх сургалтын тогтолцоог бүрдүүлж, алба хаагчдыг мэргэшүүлнэ.

6.1.7.цэргийн мэргэжлийн офицерын албан тушаалд ажиллаж байгаа тусгай мэргэжлийн офицерт цэргийн мэргэжил, тусгай мэргэжлийн офицерын албан тушаалд ажиллаж байгаа офицерт цэргийн хэргийн мэдлэг эзэмшүүлнэ.

6.1.8.төрөл мэргэжлийн ахлагч нарыг бэлтгэх сургалтын тогтолцоог хөгжүүлж, мэргэжлийн ахлагч бэлтгэнэ.

6.1.9.хилийн цэргийн анги, тусгай салбарын чиг үүрэгтэй уялдуулан хүйсийн зохистой харьцааг хангана.

6.2.Хилчдийн нийгмийн баталгааг хангах, алба хаагчийг идэвхжүүлж, урамшуулах зорилтыг хэрэгжүүлэхэд баримтлах бодлого

6.2.1.алба хаагчдын эрүүл мэнд, ажиллаж, амьдрах нөхцөл, гэр бүлийн хөгжил зэргийг хамруулсан хилчдийн нийгмийн хамгааллын хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.

6.2.2.албан хаагчдын нийгмийн баталгааг хангах эрх зүйн орчныг шинэчлэх бодлогыг хэрэгжүүлнэ.

6.2.3.ажлын гүйцэтгэлд суурилсан үнэлгээ, урамшууллын тогтолцоо бүрдүүлнэ.

6.2.4.албан хаагчдын цалин, урамшууллыг ижил төстэй, мэргэжлийн байгууллагуудаас давуу байлгана.

6.3.Хүний нөөцийн цахим мэдээллийн системийг хөгжүүлэх зорилтыг хэрэгжүүлэхэд баримтлах бодлого.

6.3.1.хүний нөөцийн цахим мэдээллийн санг хөгжүүлж, мэдээлэл, судалгааны бодит, шуурхай байдлыг хангана.

6.3.2.хүний нөөцийн цахим удирдлагын тогтолцоог бий болгож, нээлттэй, хүнд суртал, авлига, ашиг сонирхол, хөндлөнгийн нөлөөллөөс ангид байх нөхцөлийг бүрдүүлнэ.

Долоо.Хөрөнгийн эх үүсвэр.

7.1.Засгийн газраас хэрэгжүүлж буй төсөл, арга хэмжээ.

7.2.Улсын төсөв, хөрөнгө оруулалтад тусгагдсан хөрөнгө.

7.3.Хилийн цэргийн анги, тусгай салбарын үйл ажиллагааны дотоод орлого.

7.4.Хил хамгаалах байгууллагын харьяа төрийн өмчит улсын үйлдвэрийн газрын төвлөрүүлэх хөрөнгө.

Найм.Хяналт, үр дүнг тооцох.

8.1.Хөгжлийн хөтөлбөрийн үр дүн нь төлөвлөгөөний хэрэгжилтээр тодорхойлогдоно.

8.2.Хөгжлийн хөтөлбөрийн хэрэгжилтэд байгууллагын Хяналт-шинжилгээ, үнэлгээ хариуцсан нэгж дүн шинжилгээ хийнэ.

ХҮНИЙ НӨӨЦИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗАР



ХҮНИЙ НӨӨЦИЙН ХӨГЖЛИЙН ХӨТӨЛБӨРИЙГ 2022-2026 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ ТӨЛӨВЛӨГӨӨ

БАТЛАВ
 ХИЛ ХАМГААЛАХ БРОНХИЙ ГАЗРЫН ДЭРГЭДЭХ
 ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН САЛБАР ЗӨВЛӨЛИЙН
 ДАРГА,
 БРИГАДЫН ГЕНЕРАЛ *С. Дорж*
 Х.ЛХАРВАСҮРЭН
 40

2022 оны 07 дүгээр сарын 18.

ХҮНИЙ НӨӨЦИЙН ХӨГЖЛИЙН ХӨТӨЛБӨРИЙГ 2022-2026 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Суурь түвшин	Зорилтот түвшин	Төсөв (сая төгрөг)	Хугацаа	Хариуцах нэгж	Хамтран хэрэгжүүлэх нэгж
1. Байгууллагын хөгжлийн бодлоготой уялдуулсан мэргэжлийн, мэргэшсэн хүний нөөцийг бүрдүүлж, хүний хөгжлийг хангана:							
1.1. Цэргийн мэргэжлийн офицерын нөхөн хангалтыг нэмэгдүүлж, эзэмшсэн мэргэжилд тулгуурлан оновчтой, зөв байршуулна:							
1.1.1	"Хил хамгаалах байгууллагын хүний нөөцийн дүрэм"-ийг хууль, тогтоомжийн өөрчлөлттэй уялдуулан боловсруулж, хэрэгжилтийг хангах	2021 онд шинэчлэн боловсруулж, хүний нөөцийн үйл ажиллагааг зохицуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна	Байгууллагын хүний нөөцийн бодлого хууль, тогтоомжийн хүрээнд хэрэгжинэ	Үйл ажиллагааны хүрээнд	2022-2026 онд	ХНБЗГ	
1.1.2	Цэргийн тактикийн түвшиний боловсролтой хүний нөөцийг үе шаттайгаар бэлтгэж, цэргийн мэргэжлийн хүний нөөцийг бүрдүүлэх	Гадаадын болон дотоодын цэргийн их, дээд сургуульд захиалгаар 120 хүртэл сонсогчийг элсүүлэн суралцуулж байна	Цэргийн мэргэжлийн үр чадвартай, хүний нөөц бүрдэнэ	Батлагдсан төсвийн хүрээнд	2022-2026 онд	ХНБЗГ	
1.1.3	Хилийн цэргийн салбарын офицерын албан тушаалын нөхөн хангалтыг Хилийн албаны мэргэжил эзэмшсэн алба хаагчаар бүрдүүлэх	Заставын даргын албан тушаалд Хилийн албаны мэргэжил эзэмшээгүй 25 албан хаагч ажиллаж байна	Хилийн салбарын үйл ажиллагааг цэргийн мэргэжил бүхий мэргэшсэн алба хаагчаар зохион байгуулж, удирдуулна.	Үйл ажиллагааны хүрээнд	Жил бүр	ХНБЗГ	ХЦ-ийн анги, тусгай салбарын захирагч
1.2. Улсын хил хамгаалалтын арга тактикийн өөрчлөлт, шинээр нэвтрүүлэх техник технологитой уялдуулан тусгай мэргэжлийн хүний нөөцийг захилгаар бэлтгэнэ.							
1.2.1	Хил хамгаалалт, шалган нэвтрүүлэх үйл ажиллагаанд нэвтрүүлэх техник, технологийн шинэчлэлттэй уялдуулан алба хаагчдыг мэргэшүүлж, тусгай үр чадварыг үе шаттайгаар эзэмшүүлэх	Сургалтын хэрэгцээ, шаардлагыг үндэслэн хүний нөөцийн сургалтыг төлөвлөж, хэрэгжүүлэн ажиллаж байна	Шинэ техник технологийг алба, үйл ажиллагаанд шуурхай нэвтрүүлж, ашиглалт, үр дүн дээшилнэ	Батлагдсан төсвийн хүрээнд	Жил бүр	ХНБЗГ	
1.2.2	Мэдээллийн технологи, хүн, малын их эмч, сэтгэл зүйч, төрөл мэргэжлийн инженерийн мэргэжилтэй хүний нөөцийг их, дээд сургуультай хамтран	АШУИС, МУИС-ын хамтран ажиллах гэрээ, санамж бичиг байгуулсан	Тусгай мэргэжлийн хүний нөөцийн нөхөн хангалт дээшилсэн байна	Батлагдсан төсвийн хүрээнд	Жил бүр	ХНБЗГ	Холбогдох мэргэжлийн газар, хэлтэс

	хосолсон мэргэжлийн хөтөлбөр хэрэгжүүлж, бэлтгэх						
1.2.3	Байгууллагын захиалгаар суралцах тусгай мэргэжлийн төгсөх дамжааны оюутантай гэрээ байгуулж, сургалтын төлбөрийн болон бусад дэмжлэг үзүүлж, тусгай мэргэжлийн чадварлаг хүний нөөц бүрдүүлэх	Байгууллагын захиалгаар суралцаж байгаа оюутан байхгүй байна	Тусгай мэргэжлийн хүний нөөцийн нөхөн хангалт дээшилж, алба хаагчид тогтвор суурьшилтай ажиллана	Батлагдсан төсвийн хүрээнд	Жил бүр	ХНБЗГ	Холбогдох мэргэжлийн газар, хэлтэс
1.3. гадаад харилцааг өргөжүүлж, өндөр хөгжилтэй улс орнуудад алба хаагчдыг сургаж, мэргэшүүлнэ.							
1.3.1	Уламжлалт харилцаатай улс орнуудын сургалтын байгууллагуудтай сургалтын чанар, суралцагсдын сурлага, сахилгыг бэхжүүлэх талаар үүссэн цаг үеийн асуудлыг шуурхай шийдвэрлэж, хамтран ажиллах	ОХУ, БНХАУ, БНЭУ, БНСУ, АНУ-д алба хаагчдыг суралцуулж байна	Сургалтын чанар, үр дүн, суралцагсдын сахилга хариуцлага дээшилсэн байна	Батлагдсан төсвийн хүрээнд	Жил бүр	ХНБЗГ	ЗУГ
1.3.2	Гадаадын өндөр хөгжилтэй улсад албан хаагчдыг бэлтгэх, суралцуулах боломжийг нэмэгдүүлэх	ОХУ, БНХАУ, БНЭУ, БНСУ, АНУ-д алба хаагчдыг суралцуулж байна	Сургалтын чиглэлээр гадаад харилцаа хөгжиж, хамтын ажиллагаатай улс орны тоо нэмэгдсэн байна	Батлагдсан төсвийн хүрээнд	Жил бүр	ХНБЗГ	ЗУГ
1.3.3	Гадаад, дотоодын урт болон богино хугацааны сургалтад албан хаагчдыг 3 жил тутамд хамруулах	Гадаад, дотоодын урт болон богино хугацааны сургалтад 2021 онд 256 алба хаагчийг хамруулсан	Алба хаагчдыг мэдлэг, мэргэшлийн түвшин дээшилсэн байна	Батлагдсан төсвийн хүрээнд	Жил бүр	ХНБЗГ	ХЦ-ийн анги, тусгай салбарын захирагч
1.3.5	Алба хаагчдад гадаад хэлний мэдлэг олгох хөтөлбөр хэрэгжүүлэх	ХХЕГ болон бүсийн төв, шалган нэвтрүүлэх ангидад англи хэлний сургалтыг зохион байгуулж байна	Англи, Хятад, Орос хэлний дунд шатны мэдлэгтэй алба хаагчдыг тоо нэмэгдсэн байна	Батлагдсан төсвийн хүрээнд	Жил бүр	ХНБЗГ	ХЦ-ийн анги, тусгай салбарын захирагч
1.4. алба хаагчийн эзэмшсэн боловсрол, мэргэжил, ажлын дадлага, туршлага, ёс зүйн байдал, ажлын үр дүнг харгалзан удирдах болон дэвшүүлэх албан тушаалтны нөөц бүрдүүлж, шатлан дэвшүүлнэ:							
1.4.1	Байгууллагын бүтцийн нэгжийн дарга, хилийн цэргийн анги, тусгай салбарын захирагч, захирагчийн орлогч, алба тасгийн дарга нарын албан тушаалын нөөцийн бүртгэл хөтөлөх	Удирдах албан тушаалын нөөцийн бүртгэлийг хөтөлж байна	Алба хаагчийг нөөцийн бүртгэлээс дэвшүүлэн томилж, шатлан дэвших мерит зарчим хэрэгжинэ	Үйл ажиллагааны хүрээнд	Жил бүр	ХНБЗГ	ХЦ-ийн анги, тусгай салбарын захирагч
1.4.2	Удирдах болон дэвшүүлэх нөөцөд бүртгэгдэж, ажлын үр дүн, үр чадвараа нэмэгдүүлсэн, өөрийгөө хөгжүүлсэн алба хаагчийг дэвшүүлэх нээлттэй бодлого хэрэгжүүлэх	2021 онд дэвшин томилогдсон албан хаагчдын 66,6 хувь нь нөөцөд бүртгэгдсэн алба хаагчдаас томилогдсон	Нөөцийн бүртгэлээс дэвшүүлэн томилоогүй албан хаагчдын эзлэх хувь буурч, албаны идэвх нэмэгдсэн байна	Үйл ажиллагааны хүрээнд	Жил бүр	ХНБЗГ	ХЦ-ийн анги, тусгай салбарын захирагч

1.4.3	Удирдах болон дэвшүүлэх албан тушаалын нөөцөд бүртгэгдсэн алба хаагчийг цэргийн академи болон "Албан тушаалд бэлтгэх" сургалтад хамруулж, хөгжүүлэх	"Албан тушаалд бэлтгэх" сургалт нь цэргийн академийн сургалтаар хязгаарлагдаж байна	Алба хаагчдыг мэдлэг, мэргэшлийн түвшин, мэргэжлийн ур чадвар ы дээшилсэн байна	Батлагдсан төсвийн хүрээнд	Жил бүр	ХНБЗГ	ХЦ-ийн анги, тусгай салбарын захирагч
1.4.4	Нөөцөд бүртгэгдсэн алба хаагчдыг гадаад хэлний сургалтад үе шаттай хамруулж, тухайн сонгосон хэлний дундаас дээш түвшиний мэдлэг олгох	Гадаад хэлний сургалтад удирдах болон дэвшүүлэх нөөцөд бүртгэгдсэн байдлыг үндэслэн хамруулдаггүй	Удирдах бүрэлдэхүүн гадаад хэлний мэдлэг эзэмшсэн байна	Батлагдсан төсвийн хүрээнд	Жил бүр	ХНБЗГ	ХЦ-ийн анги, тусгай салбарын захирагч
1.5 Стратегийн болон оперативын түвшний боловсролтой алба хаагчийг нэмэгдүүлж, удирдах албан тушаалтныг бэлтгэнэ							
1.5.1	Цэргийн стратегийн түвшний сургалтад жилд 2-оос доошгүй алба хаагчийг суралцуулах	ХХЕГ-ын бүтцийн нэгжийн газрын дарга нарын 22 хувь нь цэргийн стратегийн түвшиний мэдлэгтэй	ХХЕГ-ын бүтцийн нэгжийн газрын дарга нарын 45 хувь нь цэргийн стратегийн түвшиний мэдлэгтэй болно Удирдах албан тушаалтны боловсролын түвшин дээшилнэ	Батлагдсан төсвийн хүрээнд	Жил бүр	ХНБЗГ	ЗУГ
1.5.2	Цэргийн оперативын түвшний боловсрол олгох сургалтад жилд 20 хүртэл алба хаагчийг суралцуулах	Байгууллагын хэмжээнд офицеруудын бүрэлдэхүүний 10 хувь нь цэргийн оперативын түвшиний мэдлэгтэй	ХХЕГ-ын газар, хэлтсийн ахлах офицер, хилийн цэргийн анги, тусгай салбарын Захирагчийн орлогч болон тасаг албаны дарга нарын 45 хүртэл хувийг цэргийн оперативын түвшиний мэдлэгтэй алба хаагчаар бүрдүүлэх Мэргэжлийн, ур чадвар бүхий гүйцэтгэх түвшиний баг бүрдэнэ	Батлагдсан төсвийн хүрээнд	Жил бүр	ХНБЗГ	ЗУГ
1.6. албан тушаалд бэлтгэх болон ажлын байран дээрх сургалтын тогтолцоог бүрдүүлж, алба хаагчдыг мэргэшүүлнэ.							
1.6.1	Төрийн албаны сургууль, ДХИС, ҮБХИС зэрэг цэргийн болон иргэний их дээд сургуулиудтай хамтран шат шатны "Албан тушаалд бэлтгэх" сургалт тасралтгүй зохион байгуулах	2022 оноос хилийн албаны тасгийн дарга, салбарын захирагч бэлтгэх сургалт зохион байгуулж, 30 алба хаагч хамруулсан	Албан тушаалд бэлтгэх сургалтад хамрагдаж, мэргэшсэн алба хаагч анги, салбарт дэвшин томилогдоно	Батлагдсан төсвийн хүрээнд	Жил бүр	ХНБЗГ	Холбогдох бүтцийн нэгжүүд
1.6.2	Сургагч багш нарыг бэлтгэж, ажлын байран дээрх сургалт зохион байгуулах	Ажлын байран дээрх сургалтыг нэгдсэн болон бүсчилсэн байдлаар зохион байгуулж байна	Ажлын байран дээрх сургалтыг үр дүнтэй зохион байгуулж, алба хаагчдын мэдлэг чадварыг дээшлүүлсэн байна	Үйл ажиллагааны хүрээнд	Жил бүр	ХНБЗГ	ХЦ-ийн анги, тусгай салбарын захирагч
1.6.3	Хилийн цэргийн анги, тусгай салбар, бүсийн төвүүдэд сургалтын материаллаг баазыг бэхжүүлж, нийт сургалтын 30 хүртэл хувийг цахим хэлбэрт шилжүүлэх	Бүсийн сургалтын төвийг байгуулж, материаллаг баазыг бэхжүүлэх шаардлагатай байна	Хилийн цэргийн анги, тусгай салбар, бүсийн төвд сургалт зохион байгуулах нөхцөл бүрдсэн байна	Батлагдсан төсвийн хүрээнд	Жил бүр	ХНБЗГ	ХЦ-ийн анги, тусгай салбарын захирагч
1.7. цэргийн мэргэжлийн офицерын албан тушаалд ажиллаж байгаа иргэний их, дээд сургууль төгссөн офицерт цэргийн мэргэжил, тусгай мэргэжлийн офицерын албан тушаалд ажиллаж байгаа офицерт цэргийн хэргийн мэдлэг эзэмшүүлнэ.							

1.7.1	Цэргийн мэргэжлийн албан тушаалд ажиллаж байгаа иргэний их дээд сургууль төгссөн офицеруудыг Хилийн албаны эчнээ сургалтаар хилийн албаны мэдлэг эзэмшүүлэх	Хилийн албаны мэргэжил олгох эчнээ сургалтад 2 жил тутам 25 алба хаагчийг харуулж байна	Мэргэжлийн хүний нөөц бүрдэнэ	Батлагдсан төсвийн хүрээнд	Жил бүр	ХНБЗГ	ХЦ-ийн анги, тусгай салбарын захирагч
1.7.2	Шалган нэвтрүүлэх албанд ажиллагсдыг мэргэшүүлж, мэргэшсэн хүний нөөцөөр хангах	Жилд 60 алба хаагчийн шалган нэвтрүүлэх албаны мэргэшүүлэх сургалтад хамруулж байна	Хилийн боомтын аюулгүй байдал, шалган нэвтрүүлэх албыг мэргэшсэн алба хаагчаар зохион байгуулна	Үйл ажиллагааны хүрээнд	Жил бүр	ХНБЗГ	ХЦ-ийн анги, тусгай салбарын захирагч
1.7.3	Төрөл мэргэжлийн инженер, хүний эмч, нягтлан, малын эмчийн тусгай мэргэжлийн офицеруудыг цэргийн мэргэжлээр мэргэшүүлэх	Жилд дунджаар 60 алба хаагчийг хамруулж байна	Офицерын анхан шатны мэдлэг эзэсхэн байна	Батлагдсан төсвийн хүрээнд	Жил бүр	ХНБЗГ	ХЦ-ийн анги, тусгай салбарын захирагч
1.8. төрөл мэргэжлийн ахлагч нарыг бэлтгэх сургалтын тогтолцоог хөгжүүлж, мэргэжлийн ахлагч бэлтгэнэ.							
1.8.1	Ахлагч бүрэлдэхүүний нөхөн хангалтыг гэрээт хилчдээс бүрдүүлж, мэргэшүүлэх	Гэрээт хилчний албаа 24 сараас дээш хугацаагаар хаасан гэрээт хилчнийг сонгон шалгаруулалтад хамруулж байна	Ахлагчийн бүрэлдэхүүний нөхөн хангалт дээшилж, мэргэшсэн алба хаагчдаар алба, үйл ажиллагааг зохион байгуулна	Үйл ажиллагааны хүрээнд	Жил бүр	ХНБЗГ	Хилийн цэргийн штаб
1.8.2	Дотоод хэргийн их сургуулийн Ахлагчийн сургуульд "Харуулын дарга бэлтгэх" нэг жилийн сургалтын хөтөлбөр хэрэгжүүлэх	"Харуулын дарга бэлтгэх" сургалтад гэрээт хилчдийг 3 сарын хугацаатай хамруулж байна	Харуулын даргын нөхөн хангалт дээшилж, мэргэшсэн алба хаагчдаар хилийн харуулыг удирдуулсан байна	Үйл ажиллагааны хүрээнд	Жил бүр	ХНБЗГ	Хилийн цэргийн штаб
1.8.3	Бүсийн төвүүдэд цэргийн мэргэжлийн ахлагч бүрэлдэхүүнийг мэргэшүүлэх сургалтын тогтолцоог бүрдүүлэх	Их, дээд сургууль болон орон нутгийн мэргэжил сургалт, үйлдвэрлэлийн төвд зарим мэргэжлийн ахлагчийг богино хугацааны сургалтад хамруулж байна	Ахлагч бүрэлдэхүүний мэдлэг, ур чадвар дээшилнэ	Батлагдсан төсвийн хүрээнд	Жил бүр	ХНБЗГ	ХЦ-ийн анги, тусгай салбарын захирагч
1.8.4	Мэргэжил сургалт, үйлдвэрлэлийн төвүүдтэй хамтран ажиллаж, тусгай мэргэжлийн ахлагч нарыг бэлтгэх	Мэргэжил сургалт, үйлдвэрлэлийн төвд жилд 170 орчим алба хаагч суралцуулж байна	тусгай мэргэжлийн ахлагч нарын нөхөн хангалтыг нэмэгдсэн байна	Батлагдсан төсвийн хүрээнд	Жил бүр	ХНБЗГ	Холбогдох мэргэжлийн газар, хэлтэс
1.9. хилийн цэргийн анги, тусгай салбарын чиг үүрэгтэй уялдуулан хүйсийн зохистой харьцааг хангана.							
1.9.1	Байгууллагын хэмжээнд цэргийн алба хаагчдын хүйсийн зохистой харьцаанд хяналт тавьж, эмэгтэй цэргийн алба хаагчдын эзлэх хувийг 20 хувиас хэтрүүлэхгүй байх	2021 оны жилийн эцсийн байдлаар цэргийн алба хаагчдын 66 хувь нь эрэгтэй, 24.1 хувь нь эмэгтэй байна	Хуулиар хүлээсэн чиг үүрэг, дээд шатын байгууллагаас тавигдсан үүргийг хэрэгжүүлэх нөхцөл хангагдсан байна	Үйл ажиллагааны хүрээнд	Жил бүр	ХНБЗГ	ХЦ-ийн анги, тусгай салбарын захирагч
1.9.2	Дотоод хэргийн их сургуулийн Хилийн албаны сургуульд Шалган нэвтрүүлэх албаны мэргэжлээр хүйсийн	2016 онд хилийн албаны мэргэжлээр 1 эмэгтэй сонсогч суралцаж төгссөн	Цэргийн мэргэжлийн офицерын жендерийн тэгш байдлыг хангана	Үйл ажиллагааны хүрээнд	Жил бүр	ХНБЗГ	

	ангилалтайгаар захиалан суралцуулах						
2.Хилчдийн нийгмийн баталгааг хангах, алба хаагчийг идэвхжүүлж, урамшуулах зорилтыг хэрэгжүүлэхэд баримтлах бодлого							
2.1.алба хаагчдын эрүүл мэнд, ажиллаж, амьдрах нөхцөл, гэр бүлийн хөгжил зэргийг хамруулсан хилчдийн нийгмийн хамгааллын хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.							
2.1.1	"Хилчдийн нийгмийн хамгаалал-2024 хөтөлбөр"-ийн хэрэгжилт, үр дүнг тооцож, хилчдийн нийгмийн хамгааллын суурь судалгааг хийх	"Хилчдийн нийгмийн хамгаалал-2024 хөтөлбөр"-ийн хэрэгжүүлэх төлөвлөгөөний хэрэгжилтийг ханган ажиллаж байна	Хилчдийн нийгмийн баталгаа шат дараатай хангагдсан байна	Батлагдсан төсвийн хүрээнд	2024 онд	ХНБЗГ	ХЦ-ийн анги, тусгай салбарын захирагч
2.1.2	"Хилчдийн нийгмийн хамгаалал-2030 хөтөлбөр" боловсруулж, хэрэгжилтийг хангах	Жил бүр хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүнг тооцож байна.	Хилчдийн нийгмийн хамгааллыг хангах чиглэлийн хэрэгцээ шаардлага тодорхойлогдсон байна	Үйл ажиллагааны хүрээнд	2024 онд	ХНБЗГ	
2.2.албан хаагчдын нийгмийн баталгааг хангах эрх зүйн орчныг сайжруулах бодлогыг хэрэгжүүлнэ.							
2.2.1	"Алслагдсан аймаг, сумдын жагсаалт"-д хилийн цэргийн анги, салбарыг хамруулах	"Алслагдсан сумын жагсаалт"-д зарим хилийн цэргийн анги, салбарыг хамрагдаагүй	Алба хаагчдад олгох тэтгэмж, тусламж эрх зүйн орчин бүрдсэн байна	Үйл ажиллагааны хүрээнд	2023 онд	ХНБЗГ	ЗУГ
2.2.2	Хилийн цэргийн анги, салбарт ажиллаж байгаа төрийн үйлчилгээний албан хаагчдад мөнгөн урамшуулал, ажилласан жилийн нэмэгдэл олгох эрх зүйн үндэслэлийг бүрдүүлэх	төрийн үйлчилгээний албан хаагчдад мөнгөн урамшуулал, ажилласан жилийн нэмэгдэл олгох эрх зүйн үндэслэл байхгүй	Хилийн цэргийн анги, салбарт ажиллаж байгаа төрийн үйлчилгээний албан хаагчдын нийгмийн хамгаалал дээшилсэн байна	Батлагдсан төсвийн хүрээнд	2023-2024 онд	ХНБЗГ	ЗУГ
2.3.ажлын гүйцэтгэлд суурилсан үнэлгээ, урамшууллын тогтолцоо бүрдүүлнэ.							
2.3.1	Хилчдийн ажлын гүйцэтгэл, үр дүнд суурилсан урамшууллын тогтолцоо бүрдүүлж, хэрэгжүүлэх	"Албан хаагчдын ажлын гүйцэтгэл, үр дүнд, мэргэшлийн түвшин үнэлэх журам"-ыг хэрэгжүүлэн ажиллаж байна	Албан хаагчдын ажлын гүйцэтгэл, албаны идэвх дээшилсэн байна	Үйл ажиллагааны хүрээнд	2024-2025 онд	ХНБЗГ	ХЦ-ийн анги, тусгай салбарын захирагч
2.3.3	Албан хаагчийн ажилласан жил, ажлын үр дүнд, гаргасан амжилтад тулгуурласан шагналын бодлогыг хэрэгжүүлэх	"Хил хамгаалах байгууллагын шагналын журам"-ыг хэрэгжүүлэн ажиллаж байна	Аливаа шагнал, урамшуулал эзнээ олсон байна	Үйл ажиллагааны хүрээнд	Жил бүр	ХНБЗГ	ХЦ-ийн анги, тусгай салбарын захирагч
2.4.албан хаагчдын цалин, урамшууллыг ижил төстэй, мэргэжлийн байгууллагуудаас давуу байлгана:							
2.4.1	Хилчдийн цалин хангамж, тусгайлсан чиг бүхий байгууллагуудын албан хаагчдын цалин, цалингийн нэмэгдлийн талаар харьцуулсан судалгаа хийж, давуу нөхцөлтэй байх боломжийг бүрдүүлэх	Тусгайлсан чиг бүхий байгууллагуудын албан хаагчдад олгох цалин, цалингийн нэмэгдлээс доогуур байна	Алслагдсан, дэд бүтцийн хөгжил хүрээгүй анги, салбаруудад алба хаагчид тогтвор суурьшилтай ажиллах нөхцөл бүрдэнэ	Батлагдсан төсвийн хүрээнд	2024-2026 онд	ХНБЗГ	ЗУГ

3. Хүний нөөцийн цахим мэдээллийн системийг хөгжүүлэх зорилтыг хэрэгжүүлэхэд баримтлах бодлого.						
3.1. хүний нөөцийн цахим мэдээллийн санг хөгжүүлж, мэдээлэл, судалгааны бодит, шуурхай байдлыг хангана.						
3.1.1	Хүний нөөцийн үйл ажиллагааны нөхцөл байдлын судалгаа хийж, хэрэгцээ шаардлагыг тодорхойлох	Шаардлагатай чиглэлийн хүрээнд тухай бүрд нь судалгаа боловсруулдаг	Хүний нөөцийн хэрэгцээг зөв тодорхойлсон байна	Үйл ажиллагааны хүрээнд	Жил бүр	ХНБЗГ
3.1.2	Хүний нөөцийн мэдээллийн системийн хөгжүүлэлтийг мэргэжлийн багаар гүйцэтгүүлэх	Хүний нөөцийн мэдээллийн систем албан хэрэгцээний шаардлага хангахгүй байна	Хүний нөөцийн мэдээллийн систем боловсронгуй болсон байна	Үйл ажиллагааны хүрээнд	2024-2026 онд	ХНБЗГ ХМТАБГ
3.1.3	Хүний нөөцийн үйл ажиллагаанд цахим шилжилтийг нэвтрүүлж, судалгаанд суурилсан, эрх зүйн үндэслэлтэй шуурхай байдлыг хангах	"Хүний нөөцийн программ"-ыг 2014 онд нэвтрүүлэн ашиглаж байна	Хүний нөөцийн холбогдолтой тайлан мэдээллийг олон төрөлт байдлаар бодитой, шуурхай, ил тод байдал хангагдана	Үйл ажиллагааны хүрээнд	2023-2026 онд	ХНБЗГ ХМТАБГ
3.2. хүний нөөцийн цахим удирдлагын тогтолцоог бий болгож, нээлттэй, хүнд суртал, авлига, ашиг сонирхол, хөндлөнгийн нөлөөллөөс ангид байх нөхцөлийг бүрдүүлнэ.						
3.2.1	Хүний нөөцийн сонгон шалгаруулалт, томилгоо, оновчтой байршуулалт, сургаж бэлтгэх цахим тогтолцоо бүрдүүлэх	Хил хамгаалах байгууллагын "Хүний нөөцийн дүрэм"-д зарчмыг баримтлан ажиллаж байна	Алба хаагчдын хөгжлийн болон карьерын ирээдүй тодорхой, нээлттэй, ил тод байх нөхцөл бүрдэнэ	Үйл ажиллагааны хүрээнд	2023-2026 онд	ХНБЗГ ХЦ-ийн анги, тусгай салбарын захирагч
3.2.2	Хүний нөөцийн удирдлагын шийдвэр гаргалтын үйл явцыг хөндлөнгийн нөлөөллөөс ангид байлгах цахим системд шилжүүлж, нээлттэй, ил тод байх цахим шийдлийг үе шаттайгаар хэрэгжүүлэх	"Хүний нөөцийн программ"-ыг 2014 онд нэвтрүүлэн ашиглаж байна	хууль дээдлэх, ёс зүйтэй, ил тод, шударга, нээлттэй авлигаас ангид чадахуйн (мерит) зарчмыг баримтлан ажилласан байна	Үйл ажиллагааны хүрээнд	2024-2026 онд	ХНБЗГ Ажлын хэсэг
3.2.3	Чадамжид суурилсан, мэргэшсэн, ур чадвартай, тэгш байдлын зарчмыг хангасан чадварлаг хүний нөөцийн ажилтныг хүний нөөцийн нэгжид байршуулах	Хүний нөөцийн дүрмийн шаардлага хангасан алба хаагчдыг сонгон хүний нөөцийн нэгжид байршуулж байна	Хүний нөөцийн ажилтны ёс зүй дээшилж, хүний нөөцийн үйл ажиллагаанд алба хаагчдын итгэл үнэмшил бүрдэнэ	Үйл ажиллагааны хүрээнд	2022-2026 онд	ХНБЗГ

БОЛОВСРУУЛСАН:
САЛБАР ЗӨВЛӨЛИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА,
ХУРАНДАА Х.ГАНТУЛГА

